ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

АРВАЙХЭЭР

2021 ОН

БАТЛАВ.
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

## НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

**1.1 Аудитын нэр, код:** Баянтээг ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудит, ӨВА-2022/1/НА-СТА-ОНА

**1.2 Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:** Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 -д заасны дагуу санхүүгийн тайлангийн аудит хийнэ.

**1.3 Аудитын ажлын зорилго:** Баянтээг ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлж үнэн зөв толилуулсан эсэхэд санал дүгнэлт өгөхөд чиглэнэ.

**1.4 Аудитын ажлын шинж чанар, хугацаа, хамрах хүрээ:** Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудит хийх байгууллагын жагсаалт, аудит хийх хэлбэр батлах тухай" 2021 оны А/87 дүгээр тушаалыг үндэслэн санал дүгнэлт гаргана.

Аудитыг ахлах аудитор С.Шийлэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Аудитад 2021 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, анхан шатны баримт, үйл ажиллагааны тайлан болон бусад шаардлагатай баримтуудыг хамруулна.

Санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлд тусгасан асуудлуудыг тусгайлан авч үзэж, үр дүнг тайлагнахаар энэхүү төлөвлөгөөнд тусгасан.

**1.5 Аудитын урьдчилсан үйл ажиллагааны үр дүн:** Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг хүлээн зөвшөөрөхүйц гэдгийг тодорхойлж, аудитын баг Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн дүрэмд заасан шаардлагууд болон үүрэг хариуцлагыг бүрэн ойлгож мэдэгдэл гаргасан бөгөөд ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдсэн болно.

Мөн аудитын ажлын захидлыг 2021 оны 12 дугээр сарын 16-ны өдрийн 422 дугаар албан бичгээр шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж талуудын хүлээх үүрэг, хариуцлага болон аудитын урьдчилсан нөхцөлүүдийг харилцан тохиролцох, аудит хийх багийг танилцуулах нээлтийн уулзалтыг хянан удирдах ажилтнуудын оролцоотой гүйцэтгэж тэмдэглэл хөтөлсөн.

**1.6 Төлөвлөх үе шатанд хийсэн ажлууд, тэдгээрийн үнэлгээ:** Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", 2021 оны А/70 дугаар тушаалаар баталсан "Санхүүгийн тайлангийн

аудитын заавар, аргачлал"-ын дагуу аудитыг төлөвлөх үе шатны ажлыг бүрэн гүйцэтгэж, аудитын ажлын баримт бэлтгэж, хянуулсан.

**1.6.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналтыг ойлгож эрсдэлтэй асуудлыг тодорхойлох:** Баянтээг ХК нь Уул уурхай салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ойрын аймгуудыг илчлэг сайтай чанартай нүүрсээр тасралтгүй хангаж, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шудрага үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх, орон нутгийнхаа өсөлт дэвшилд гар бие оролцоход оршино.

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон. Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

**1.6.2 Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг тодорхойлох:** Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалж, суурь үзүүлэлтийг 2021 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн борлуулалтын орлогын дүнг сонгосон.

Материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлж, материаллаг байдлын түвшин 1 хувиар тогтоож, сонгосон суурь үзүүлэлтээс тооцож төлөвлөлтийн материаллаг байдлыг 73.6 сая төгрөгөөр тогтоож баримтжууллаа.

Дээрх ажлын баримтад материаллаг байдлын суурь үзүүлэлт, хувь хэмжээг сонгосон шалтгаан, тайлбар болон материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзэх шалтгаан, тайлбарыг тусгасан болно.

Мөн санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 41.5 сая төгрөгөөр тогтоолоо.

**1.6.3 Эрсдэлийн үнэлгээний үр дүн:** Байгууллага, түүний орчин, дотоод хяналтын талаар ойлголт авч, эрсдэлийн үнэлгээний горимыг үндэслэн санхүүгийн тайлангийн түвшинд, батламж мэдэгдлийн түвшинд уламжлалт болон хяналтын эрсдэлийг тодорхойлж, бүртгэсэн.

Тодорхойлсон эрсдэлүүдээс нөлөө бүхий эрсдэлийг эрэмбэлж, үнэлсэн бөгөөд холбогдох хяналт, түүний дотор хяналтын үйл ажиллагааг авч үзсэн.

Мөн ач холбогдолтой биш боловч материаллаг байж болзошгүй эрсдэлүүдийг бүртгэж шинж чанарын хувьд материаллаг эсэх, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлд нөлөөлөх эсэхийг үнэлсэн.

Эрсдэлийн үнэлгээнээс хамаарч нөлөө бүхий 6 эрсдэл тодорхойлж бие даасан горим болон хяналтын сорил хэрэгжүүлэхээр баримтжуулав.

**1.6.4 Үнэлсэн эрсдэлд өгөх ерөнхий хариу:** Үнэлсэн эрсдэлд өгөх ерөнхий хариуг зохиомжилж аудитыг гүйцэтгэх үе шатанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бие даасан горим болон хяналтын сорилд хамаарах батламж мэдэгдэл, стандартын болон хууль тогтоомжтой холбоотой шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлэх хугацааг тодорхойлов.

**1.6.5 Аудитын үр өгөөжийн урьдчилсан төлөвлөлт**: Санхүүгийн тайлангийн аудитаар 10.0 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болгохоор урьдчилан тооцоолж, шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд чанарын ахиц, дэвшил гарсныг санхүүгийн бус үр өгөөжөөр бүртгэхээр төлөвлөв.

**1.7 Санхүүгийн тайлангийн аудитад ашиглах нөөц:** Аудитад ашиглах нөөцийг дараах байдлаар тодорхойлов.

**1.7.1 Аудит хийх багийн бүрэлдэхүүн, гүйцэтгэх үүрэг:**

| дд | Багийн гишүүдийн | | Аудитын явцад гүйцэтгэх үүрэг |
|---|---|---|---|
| | Овог нэр | Албан тушаал | |
| 1 | Д.Гансүх | Аудитын менежер | Аудитын үе шатны хяналт хэрэгжүүлэх, арга зүйгээр хангах |
| 2 | С.Шийлэгмаа | Ахлах аудитор | Аудитыг гүйцэтгэх |

**1.7.2 Аудитад зарцуулах хугацаа, төсөв:**

| дд | Багийн гишүүдийн | | Аудитад зарцуулах хугацаа (хүн/өдөр) | Аудитад зарцуулах төсөв (мян.төг) | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Овог нэр | Албан тушаал | | Цалин | Томилолт | Бусад | Дүн |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Д.Гансүх | Аудитын менежер | 3 | 139.0 | | | 417.0 |
| 2 | С.Шийлэгмаа | Ахлах аудитор | 3 | 139.0 | | 50.0 | 467.0 |
| | Дүн | | 6 | 139.0 | | 50.0 | 884.0 |

## ХОЁР. АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭХ ҮЕ ШАТАНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ГОРИМ, СОРИЛ

| Хэрэгжүүлэх горим, сорилууд | | Аудитын горимын | | |
|---|---|---|---|---|
| | | Шинж чанар | Хугацаа | Хамрах хүрээ |
| **2.1 Санхүүгийн тайлангийн түвшинд** | | | | |
| 1. | Шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулаагүй, хяналт тавиагүй байх | Мэргэжлийн үл үзлээр хандах | 2022.02.15-2022.02.20 | 2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд |
| **2.2 Батламж мэдэгдлийн түвшинд** | | | | |
| 1 | Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн | Бие даасан горим | 2022.02.15-2022.02.20 | 2021 оны Санхүүгийн |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжүүлээгүй байх. | | | тайлан, баримтууд |
| 2 | Ковид 19 цар тахалтай холбоотой айл өрх, аж ахуйн нэгжид үзүүлсэн хөнгөлөлтийн орлогыг зориулалт бусаар зарцуулсан байх. | Бие даасан горим | 2022.02.15-2022.02.20 | 2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд |
| 3 | Хөрөнгийн тооллогыг хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байх | Хяналтад найдах | 2022.02.15-2022.02.20 | 2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд |
| **2.3 Бусад төлөвлөсөн горимууд** | | | | |
| 1 | Нягтлан бодогч эд хариуцагчийн тайланг хянаж, хүлээн аваагүй байх | Шалгалт | 2022.02.15-2022.02.20 | 2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд |
| 2 | Толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байх | Шалгалт | 2022.02.15-2022.02.20 | 2021 оны Санхүүгийн тайлан, баримтууд |

## ГУРАВ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ХӨТӨЛБӨР

| № | Хийгдэх ажил | Зарцуулах өдөр /тоогоор/ | Эхлэх өдөр | Дуусах өдөр | Хариуцах ажилтны албан тушаал, овог, нэр |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Аудитын урьдчилсан үйл ажиллагаа | **3** | 2021.12.23 | 2021.12.26 | Ахлах аудитор С.Шийлэгмаа |
| 2 | Аудитыг төлөвлөх | **1** | 2021.12.27 | 2021.12.28 | Ахлах аудитор С.Шийлэгмаа |
| 3 | Аудитыг гүйцэтгэх | **2** | 2022.02.25 | 2022.03.10 | Ахлах аудитор С.Шийлэгмаа |
| 4 | Дуусгавар болох ба дахин хянах | **1** | 2022.03.10 | 2022.03.15 | Ахлах аудитор С.Шийлэгмаа |
| 5 | Аудитыг тайлагнах | **1** | 2022.03.15 | 2022.03.15 | Ахлах аудитор С.Шийлэгмаа |
| 6 | Аудитын дараах үйл ажиллагаа | **84** | 2022.03.25 | 2022.04.25 | Ахлах аудитор С.Шийлэгмаа |

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ:

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР: /Д.ГАНСҮХ/

Огноо:

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР С. Шийлэгмаа /С.ШИЙЛЭГМАА/
Огноо: 2021.12.28

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянтээг ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨВА-2022/1/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Арвайхээр сум

2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Ахлах аудитор: С.Шийлэгмаа

Утас: 70323833 Цахим хаяг: Shiilegmaas@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.Аудитын санал дүгнэлт ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ........ 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан ........ 5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ........ 8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга ........ **Error! Bookmark not defined.**
3.1 Байгууллагын үйл ажилагаа ........ 9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин ........ 9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ........ 10
4. Аудитын тайлан ........ 9
4.1 Ерөнхий зүйл ........ 12
4.2 Дотоод хяналт ........ 13
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 13
4.4 Материаллаг байдал ........ 13
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
5.1 Шилэн дансны мэдээлэл ........ 14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14
8. Аудитын илрүүлэлт ........ 14
8.1 Залруулсан алдаа ........ 15
8.2 Төлбөрийн акт ........ 15
8.3 Албан шаардлага ........ 15
8.4 Зөвлөмж ........ 15
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 0


### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.Аудитын санал дүгнэлт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022. 03. [illegible] № 226

танай ____________-ны №____________-т

БАЯНТЭЭГ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ДАНЗАН ТАНАА

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянтээг ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянтээг ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээд харааг бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.
2. Газар эзэмших эрхийн үнэлгээг нормативын аргыг ашиглан үнэлж бүртгээгүй байна.
3. Нийт авлагаас 184.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.
4. Тэтгэмж, урамшууллын зардлаас: Аймаг, сум, орон нутгийн нэрийг алдаршуулж буй спортын тамирчинд 10.0 сая төгрөг, байгууллагуудын түүхт 100 жилийн ойн зориулан 11.5 сая төгрөг, Бөхийн холбоонд 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.
5. Компани нь нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд нийт цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын ажил хийх эрхтэй боловч 10 хувиас хэтрүүлэн 2021 онд 1.0 тэрбум төгрөгийг төлөвлөж, зарцуулсан.
6. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 207 тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 25 дугаар зүйлийн 25.10, Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Компанийн дүрмийн 7.3.131, Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 182, 207 дугаар тушаалуудыг зөрчсөн, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал, гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

0150306

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Байгууллагын нэр: Баянтээг**

**Санхүүгийн байдлын тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,816,501,278.00** | **5,026,100,348.00** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **2,282,800,447.00** | **3,144,375,643.00** |
| 31100 | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | **33,799,617.00** | **15,868,152.00** |
| 31110 | Төгрөг | 33,799,617.00 | 15,868,152.00 |
| 31200 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **2,249,000,830.00** | **3,128,507,491.00** |
| 31210 | **Төгрөг** | **2,249,000,830.00** | **3,128,507,491.00** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 2,249,000,830.00 | 3,128,507,491.00 |
| 33 | **АВЛАГА** | **1,156,598,379.00** | **1,292,815,213.00** |
| 33401 | Дансны авлага /ТӨҮГ/ | 1,130,379,691.00 | 1,292,749,273.00 |
| 33402 | Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/ | 26,218,688.00 | 65,940.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | **211,738,449.00** | **349,775,369.00** |
| 35100 | **Түүхий эд материал** | **35,554,701.00** | **182,526,574.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 35,554,701.00 | 182,526,574.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 65,532,900.00 | 45,560,031.00 |
| 35400 | **Хангамжийн материал** | **110,650,848.00** | **121,688,764.00** |
| 35470 | Бусад хангамжийн материал | 110,650,848.00 | 121,688,764.00 |
| 36 | **НӨӨЦИЙН БАРАА** | **165,364,003.00** | **239,134,123.00** |
| 36600 | Бусад нөөц | 165,364,003.00 | 239,134,123.00 |
| 360 | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | **0.00** | **0.00** |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **5,589,705,579.00** | **6,050,123,827.00** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **5,589,705,579.00** | **6,050,123,827.00** |
| 39200 | **Биет хөрөнгө** | **5,587,721,079.00** | **5,236,578,271.00** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,376,827,200.00 | 2,394,719,700.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,551,047,977.00 | -1,610,594,822.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 3,303,048,278.00 | 3,303,048,278.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -1,675,005,438.00 | -1,877,789,163.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 3,964,662,698.00 | 4,157,230,609.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -2,826,502,940.00 | -3,128,976,236.00 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 108,649,709.00 | 122,024,254.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -55,121,577.00 | -65,295,475.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 1,942,211,126.00 | 1,942,211,126.00 |
| 39300 | **Биет бус хөрөнгө** | **1,984,500.00** | **1,984,500.00** |
| 39301 | Програм хангамж | 2,220,000.00 | 2,220,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -235,500.00 | -235,500.00 |
| 39400 | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | **0.00** | **811,561,056.00** |
| 39402 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө /ТӨҮГ/ | 0.00 | 811,561,056.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **9,406,206,857.00** | **11,076,224,175.00** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,054,163,121.00** | **1,105,840,945.00** |
| 41 | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **282,722,217.00** | **334,400,041.00** |
| 41300 | **Өглөг** | **282,722,217.00** | **334,400,041.00** |
| 41360 | **Бусад өглөг** | **282,722,217.00** | **334,400,041.00** |
| 41363 | Татварын өглөг /ТӨҮГ/ | 216,153,941.00 | 309,393,548.00 |
| 41365 | Ноогдол ашгийн өглөг /ТӨҮГ/ | 46,547,596.00 | 0.00 |
| 41366 | Дансны өглөг /ТӨҮГ/ | 20,020,680.00 | 25,006,493.00 |
| 42 | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **771,440,904.00** | **771,440,904.00** |
| 42200 | **Урт хугацаат зээл** | **771,440,904.00** | **771,440,904.00** |
| 42210 | **Төгрөг** | **771,440,904.00** | **771,440,904.00** |
| 42214 | Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн зээл | 771,440,904.00 | 771,440,904.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **8,352,043,736.00** | **9,970,383,230.00** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **8,352,043,736.00** | **9,970,383,230.00** |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 17,682,500.00 | 17,682,500.00 |
| 51102 | Өмч /хувийн/ /ТӨҮГ/ | 7,578,300.00 | 7,578,300.00 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 605,167,428.00 | 605,167,428.00 |
| 51200 | **Хуримтлагдсан үр дүн** | **6,698,230,156.00** | **8,316,569,650.00** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,964,178,949.00 | 6,698,230,156.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,734,051,207.00 | 1,618,339,494.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,023,385,352.00 | 1,023,385,352.00 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **9,406,206,857.00** | **11,076,224,175.00** |

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

**Байгууллагын нэр: Баянтээг**

**Санхүүгийн үр дүнгийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,005,129,423.00** | **7,359,600,365.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,005,129,423.00** | **7,359,600,365.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **3,005,129,423.00** | **7,359,600,365.00** |
| 120002 | Хүүгийн орлого | 47,390,614.00 | 0.00 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **0.00** | **7,339,228,465.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 7,305,424,359.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 33,804,106.00 |
| 120009 | Бусад орлого | 69,896,829.00 | 20,371,900.00 |
| 120010 | Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/ | 5,849,927,418.00 | 0.00 |
| 120011 | Борлуулалтын өртөг /ТӨҮГ/ | 2,962,085,438.00 | 0.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,271,078,216.00** | **5,741,260,871.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,271,078,216.00** | **5,417,534,236.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,271,078,216.00** | **5,292,622,236.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **0.00** | **1,315,769,015.00** |
| 210101 | Үндсэн цалин | 0.00 | 1,205,556,764.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 110,212,251.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **0.00** | **180,833,562.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.00 | 180,833,562.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **0.00** | **154,890,748.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.00 | 122,195,645.00 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 32,695,103.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **0.00** | **1,140,290,313.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 3,683,330.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 842,244,588.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0.00 | 17,444,809.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.00 | 665,050.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 0.00 | 244,162,626.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 0.00 | 32,089,910.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **0.00** | **49,027,442.00** |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 49,027,442.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0.00** | **50,338,537.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.00 | 50,338,537.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **0.00** | **10,304,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 10,304,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,271,078,216.00** | **1,816,190,855.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 13,514,586.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 6,468,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 2,323,200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 1,397,020.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 330,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 57,793,020.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.00 | 566,751.00 |
| 210810 | Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/ | 0.00 | 6,250,000.00 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ | 1,078,405,816.00 | 1,000,000,000.00 |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | 0.00 | 547,732,779.00 |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/ | 192,672,400.00 | 179,815,499.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **0.00** | **574,977,764.00** |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 0.00 | 574,977,764.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.00** | **124,912,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **124,912,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 49,912,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 75,000,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **323,726,635.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **0.00** | **323,726,635.00** |
| 221001 | Их засвар | 0.00 | 323,726,635.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,734,051,207.00** | **1,618,339,494.00** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **1,734,051,207.00** | **1,618,339,494.00** |
| VI-I | Засгийн газрын хувь оролцоо | 1,213,835,845.00 | 1,132,837,646.00 |
| VI-II | Хяналтын бус хувь оролцоо | 520,215,362.00 | 485,501,848.00 |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Баянтээг

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **657,743,300.00** | **1,023,385,300.00** | **5,764,179,000.00** | **7,445,307,600.00** |
| 2 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| 3 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **657,743,300.00** | **1,023,385,300.00** | **5,764,179,000.00** | **7,445,307,600.00** |
| 4 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| 5 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **-9.00** | **52.00** | **-51.00** | **-8.00** |
| 6 | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| 7 | **Өмчид гарсан өөрчилөлт** | **-27,315,063.00** | **0.00** | **0.00** | **-27,315,063.00** |
| 8 | **Зарласан ногдол ашиг** | **0.00** | **0.00** | **-800,000,000.00** | **-800,000,000.00** |
| 9 | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **1,734,051,207.00** | **1,734,051,207.00** |
| 10 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **630,428,228.00** | **1,023,385,352.00** | **6,698,230,156.00** | **8,352,043,736.00** |
| 11 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **630,428,228.00** | **1,023,385,352.00** | **6,698,230,156.00** | **8,352,043,736.00** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 13 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **630,428,228.00** | **1,023,385,352.00** | **6,698,230,156.00** | **8,352,043,736.00** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 1,618,339,494.00 | 1,618,339,494.00 |
| 20 | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **630,428,228.00** | **1,023,385,352.00** | **8,316,569,650.00** | **9,970,383,230.00** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Байгууллагын нэр: Баянтээг**

**Мөнгөн гүйлгээний тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,090,687,508.00** | **7,955,483,953.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **0.00** | **724,666.00** |
| **112** | **Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого** | **0.00** | **724,666.00** |
| 112002 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 0.00 | 724,666.00 |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,090,687,508.00** | **7,954,759,287.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **6,090,687,508.00** | **7,954,759,287.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **0.00** | **7,952,963,877.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 7,923,821,273.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 29,142,604.00 |
| 120009 | Бусад орлого | 0.00 | 1,795,410.00 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/ | 6,090,687,508.00 | 0.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,453,381,137.00** | **6,127,795,061.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,453,381,137.00** | **6,127,795,061.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,453,381,137.00** | **6,002,883,061.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **874,628,575.00** | **1,134,631,870.00** |
| 210106 | Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/ | 874,628,575.00 | 1,134,631,870.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **285,400,000.00** | **343,320,000.00** |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 285,400,000.00 | 343,320,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **104,248,846.00** | **134,415,210.00** |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | 104,248,846.00 | 134,415,210.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **1,447,804,068.00** | **2,293,033,216.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 3,683,330.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 1,097,550,307.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 0.00 | 19,189,290.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.00 | 665,050.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/ | 887,944,822.00 | 217,815,774.00 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/ | 559,859,246.00 | 954,129,465.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **0.00** | **26,924,775.00** |
| 210502 | Хоол, хүнс | 0.00 | 26,924,775.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0.00** | **41,617,121.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.00 | 41,617,121.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **0.00** | **10,304,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 0.00 | 10,304,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,741,299,648.00** | **2,018,636,869.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 14,866,045.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 6,468,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 1,397,020.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 330,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 57,793,020.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 0.00 | 566,751.00 |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 959,001,751.00 | 934,892,833.00 |
| 210817 | Даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 1,399,200.00 | 2,323,200.00 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/ | 1,780,898,697.00 | 1,000,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.00** | **124,912,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **0.00** | **124,912,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 49,912,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 75,000,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **637,306,371.00** | **1,827,688,892.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **47,390,614.00** | **0.00** |
| 140007 | Хүлээн авсан хүүний орлого | 47,390,614.00 | 0.00 |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **695,617,734.00** | **1,035,396,012.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **695,617,734.00** | **1,035,396,012.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **695,617,734.00** | **1,035,396,012.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 695,617,734.00 | 1,035,396,012.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-648,227,120.00** | **-1,035,396,012.00** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-753,452,404.00** | **69,282,316.00** |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **753,452,404.00** | **-69,282,316.00** |
| 250005 | Төлсөн ногдол ашиг | 753,452,404.00 | -69,282,316.00 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-764,373,153.00** | **861,575,196.00** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,047,173,600.00 | 2,282,800,447.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,282,800,447.00 | 3,144,375,643.00 |

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **7038056800.00** | **5741260871.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 6578056800.00 | 5417534236.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДА.** | 6453056800.00 | 5292622236.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1328735300.00 | 1315769015.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1208735300.00 | 1205556764.00 |
| 210104 | Урамшуулал | 120000000.00 | 110212251.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлө** | 187354000.00 | 180833562.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | 187354000.00 | 180833562.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зар** | 171502000.00 | 154890748.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 125900000.00 | 122195645.00 |
| 210302 | Түлш, халаалт | 45602000.00 | 32695103.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1306214800.00 | 1140290313.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4889400.00 | 3683330.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 946526000.00 | 842244588.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19370000.00 | 17444809.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 2000000.00 | 665050.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 117989400.00 | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 15000000.00 | 32089910.00 |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/ | 200440000.00 | 244162626.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 45360000.00 | 49027442.00 |
| 210502 | Хоол, хүнс | 45360000.00 | 49027442.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 89593600.00 | 503338537.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 89593600.00 | 503338537.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 18937000.00 | 10304000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 18937000.00 | 10304000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээни** | 2509073000.00 | 1363190855.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажи | 75000000.00 | 13514586.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 6500000.00 | 6468000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2355000.00 | 2323200.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 2000000.00 | 1397020.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 440000.00 | 330000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 8000000.00 | 57793020.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээ | 550000.00 | 566751.00 |
| 210810 | Борлуулалт, маркетингийн зардал | 10000000.00 | 6250000.00 |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал | 1000000000.00 | 1000000000.00 |
| 210812 | Санхүүгийн зардал | 1016101400.00 | |
| 210813 | Бусад зардал | 388126600.00 | 94732779.00 |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/ | 0.00 | 179815499.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 671287100.00 | 574977764.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоригдол | 671287100.00 | 574977764.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 125000000.00 | 124912000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 125000000.00 | 124912000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, ура | 50000000.00 | 49912000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуула | 75000000.00 | 75000000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **460000000.0** | **323726635.0** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 460000000.0 | 323726635.0 |
| 221001 | Их засвар | 460000000.00 | 323726635.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үл** | 0.00 | 0.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн ү.** | 0.00 | 0.00 |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Баянтээг ХК-ийн зорилго нь Уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, ойрын аймгуудыг илчлэг сайтай чанартай нүүрсээр тасралтгүй хангаж, хэрэглэгчдэд хөнгөн шуурхай, шударга үйлчилгээ үзүүлэх, тус салбарт явуулж буй төрийн бодлогыг хэрэгжүүлэх, орон нутгийнхаа өсөлт дэвшилд гар бие оролцоход оршино.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг "Хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай нүүрс олборлон, борлуулах замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг ханган ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн" гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит статустай байна. Өмчийн 70 хувийг орон нутаг, үүнээс Шунхлай групп 24 хувь, жижиг хувьцаа эзэмшигч 6 хувийг эзэмшиж байна.

### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

МАХН-ын ТХ, СНЗ-ийн 1961 оны 4-р сарын 26-ны өдрийн 191/142-р тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Өвөрхангай аймгийн өмч хувьчлалын комисс 1994 оны 11-р тогтоолоор

Баянтээг нүүрсний уурхайг хувьчлах шийдвэр гарч, энэ дагуу "Баянтээг" ХК болон зохион байгуулагдсан байна. Хувьчлал явагдаж дууссанаар 1995 оны 9 сард Аж ахуйн

нэгжийн тухай хуулийн дагуу Баянтээгийн уурхай "Баянтээг ХК" болон өөрчлөгдөж, компанийн 25260.0 мянган төгрөгийн дүрмийн сангийн 70 хувь нь төрийн өмч буюу орон нутгийн засаг захиргааны мэдэлд, 30 хувь хувьцаа эзэмшигчдийн хамтын өмч болж, шинэ зохион байгуулалтад шилжсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..." гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэй томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дэх заалттай нийцэж байна.

Баянтээг ХК-ний Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 33.9 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалтай нийцэж байна.

Өвөрхангай аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Аймгийн засаг даргын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.3.1-т "Орон нутгийн хөгжил, эдийн засгийн өсөлтийг хангах уул уурхайн орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулж хариуцлагатай уул уурхайг дэмжинэ" гэж заасан байна. Энэ хүрээнд тайлант онд Баянтээгийн уурхайн нөөцийг нэмэгдүүлэх, өмнөх нөөцийг баталгаажуулах зорилгоор нүүрсний уурхайн баруун хэсэгт нарийвчилсан хайгуулын ажил гүйцэтгэх тендер зарлаж Галаксигео монголиа ХХК шалгаран үйл ажиллагаагаа эхлүүлэн хээрийн ажлын явц 80 хувьтай явагдаж байна. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 73 дугаар тогтоолоор Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглэн байгуулах цахилгаан станц барих ажлыг эрчимжүүлэх чиглэлээр 5 арга хэмжээ авч, хэрэгжүүлж ажиллах талаар аймгийн Засаг даргат үүрэг болгосон байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй, чиг үүргийн давхардлыг арилгаж 15 орон тоог бууруулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан тогтоосон байна. Шагнал урамшуулал олгосон, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардал гаргасан зөрчил илрээгүй болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйл

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Баянтээг ХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 2,282,800.4 | 3,144,375.6 | 861,575.2 |
| БХХО | | | |
| Авлага | 1,156,598.4 | 1,292,815.2 | 136,216.8 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 377,102.4 | 588,909.5 | 211,807.1 |
| Үндсэн хөрөнгө | 5,589,705.6 | 6,050,123.8 | 460,418.2 |
| Биет бус хөрөнгө | 1,984.5 | 813,545.5 | 811,561.0 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **9,471,739.7** | **11,076,224.2** | **1,604,484.5** |
| Өр төлбөрийн дүн | | | |
| Богино хугацаат өглөг | 282,722.2 | 334,400.0 | 51,677.8 |
| Урт хугацаат өглөг | 771,440.9 | 771,440.6 | - |
| Эздийн өмч | | | |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **9,406206.9** | **11,076,224.2** | **1,670,017.3** |

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд 3 тэрбум 144.4 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд борлуулалтын авлага 1 тэрбум 292.7 сая төгрөг, НДШ-ийн авлага 65.9 мянган төгрөгийг эзэлж байна.

Тайлант онд нүүрс борлуулсны хүрээнд үүссэн аж ахуйн нэгжээс авах авлага 136.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 758.7 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 534.0 сая төгрөгийг найдваргүй авлагаар тооцоогүй байна. Харин Номгон хайрхан ХХК-ийн 8.7 сая төгрөгийн авлагыг захиргааны хэргийн шүүхэд шилжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 588.9 сая төгрөг болж 211.8 сая төгрөгөөр өссөн оны өмнө тээвэр шатахууны зардлаас 182.5 сая төгрөгийн 73 тонн дизелийн түлш нөөцөлсөн мөн 29.3 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл нөөцөлснөөс шалтгаалжээ.

Тайлант онд худалдан авалтаар 1 тэрбум 35.4 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. Үүнээс: - Биет бус хөрөнгөд 811.6 сая төгрөгийн нөөцийн хайгуул хийсэн.

- Барилга байгууламжид - Зөөврийн гал тогоо 17.9 сая төгрөг
- Машин тоног төхөөрөмжид 192.6 сая төгрөг
- Тавилга эд хогшилд 13.4 сая төгрөг

Үндсэн хөрөнгийн данснаас хөрөнгө актлагдаагүй байна.

Биет бус хөрөнгө 811.6 сая төгрөгөөр өссөн нь нөөцийн хайгуул хийснээс шалтгаалжээ.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 12 тэрбум 733.0 сая төгрөгийн хөрөнгүүдийг нь өөрөө бүрэн ашиглаж байгаа нь санхүүгийн тайлангийн оршин байх батламж мэдэгдлийг хангаж байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 334.4 сая төгрөгийн өр төлбөр байна. Урт хугацаат өр төлбөр дансанд: 2010 онд Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсний нөхөн төлбөр тогтоосноос шалтгаанаас үүссэн 630.1 сая төгрөг буюу 459.2 мянган ам долларын өр төлбөр үүссэн.

Өр төлбөрийг 2011-2015 он хүртэл 27.7 сая төгрөгийг төлсөн. Үлдэгдэл төлбөр болох 602.4 сая төгрөгийг барагдуулаагүй байтал Монголиан бизнес рейтинг аудит ХХК

2015 оны санхүүгийн тайлангийн баталгаажуулах аудитаар ханшийн тэгшитгэл хийж 224.7 сая төгрөгөөр өрийг нэмэгдүүлж 847.1 сая төгрөг болгосон байна. 2015-2018 онуудад нийт 135.7 сая төгрөгийн өрийг төлж, 711.4 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна. Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь Ашигт малтмалын газрын нүүрс судалгааны хэлтсээс эргэн төлөлтийн хуваарийг шинэчлэн тогтоож өгөөгүйгээс шалтгаалсан байна.

Шалгагдагч байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна. Зардал өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 1 тэрбум 508.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд 1.0 тэрбум төгрөг, хөрс хуулалт талбай өмнөх оноос 203 $м^3$-ээр илүү хөрс хуулсны зардалд зарцуулснаас шалтгаалжээ.

### 3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй".

Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 3 дугаар тогтоолоор Баянтээг ХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 6 тэрбум 972.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 6 тэрбум 972.5 сая төгрөгөөр, тэг төгрөгийн ашиг /алдагдал/ байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 1 тэрбум 857.6 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 7 тэрбум 359.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 5 тэрбум 741.3 сая төгрөгийн зардал гарган, 1 тэрбум 618.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 7 тэрбум 359.6 сая төгрөг болж төлөвлөснөөс 387.1 сая төгрөг буюу 5.5 хувиар давсан бусад аймгийн хэрэглэгчид нэмэгдсэн зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 5 тэрбум 741.3 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1 тэрбум 231.2 сая төгрөг буюу 17.7 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь зарим төлөвлөгдсөн зардлууд ковид-19 болж гараагүй нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 12 нэр төрлийн 17 ажилд өөрийн эх үүсвэрээс 1 тэрбум 180.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 1 тэрбум 857.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1 тэрбум 857.6 сая төгрөгөөр илүү байгаа нь нүүрсний борлуулалт давуулан биелүүлсэн мөн хэмнэгдсэн зардлаас нөлөөлж байна.

## 4. Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянтээг ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэлийн хуультай холбоотой өгсөн 2 зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Шийлэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянтээг ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 9 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компани Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Баянтээг ХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт борлуулалтын орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 7 тэрбум 359.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 73.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд нийт 7 тэрбум 985.1 сая төгрөгийн 293 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас бүрэн байршуулсан байна.

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

## 6. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 237.3 сая төгрөгийн зөрчилд 0.4 төлбөрийн акт, 236.9 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, акт 100 хувь, албан шаардлага 100 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 3.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 0.4 | 1 | 0.4 | | | |
| Албан шаардлага | 1 | 236.9 | 1 | 236.9 | | | |
| Зөвлөмж | | | | | | | |
| Нийт дүн | 2 | 237.3 | 2 | 237.3 | | | |

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын гүйцэтгэх захирлын шийдвэрээр олгосон цалингийн нэмэгдэл, урамшуулалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх цаг хугацааны боломж гараагүй тул дараагийн аудитаар анхаарах болно.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3 тэрбум 617.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 32.1 сая төгрөгийн алдааг залруулж, 3 тэрбум 585.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 3 тэрбум 585.6 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 73.6 сая төгрөгийн түвшнээс 3 тэрбум 512.0 сая төгрөгөөс /их/ байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 32.1 сая төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд: Бараа материалаас акталсан 32.1 сая төгрөгийн материалыг өмчийн өөрчлөлтийн тайланд шууд хаасан бичилт хийсэн байсан.

### 8.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### 8.3 Албан шаардлага

1. Нийт авлагаас 184.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

2. Тэтгэмж, урамшууллын зардлаас: Аймаг, сум, орон нутгийн нэрийг алдаршуулж буй спортын тамирчинд 10.0 сая төгрөг, байгууллагуудын түүхт 100 жилийн ойн зориулан 11.5 сая төгрөг, Бөхийн холбоонд 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

3. Компани нь нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд нийт цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын ажил хийх эрхтэй боловч 10.0 хувиас хэтрүүлэн 2021 онд 1.0 тэрбум төгрөгийг төлөвлөж, зарцуулсан.

4. Сангийн сайдын 2018 оны 207 тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ын дагуу 2 тэрбум 376.8 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийж санхүүгийн тайланд тусгаагүй байна.

### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. НББ-н хуультай холбоотой асуудал***

_Илрүүлэлт:_

*НББ-ийн тухай хуулийн 18.2. “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана “ гэснийг мөрдлөг болгон ажиллаагүй тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна.*

_Өгсөн зөвлөмж:_

***Нягтлан болох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулна мөрдөж ажиллах.***

***2. Биет бус хөрөнгөтэй холбоотой асуудал***

_Илрүүлэлт:_

_Газар эзэмших эрхийн үнэлгээг хийлгэж Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг мөрдөж ажиллаагүйгээс Газар эзэмших эрхийн үнэлгээг нормативын аргыг ашиглан үнэлж бүртгээгүй байна._

_Өгсөн зөвлөмж:_

_Газар эзэмших эрхийн үнэлгээг нормативын аргыг ашиглан үнэлж бүртгэлт тусгаж ажиллах._

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үнээс: Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Хариуцлага тооцох | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Баянтээг ХК | ӨВА-2022/1/НА-СТА-ОНА | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна. | НББ-ийн тухай хуулийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана | | | | | | | | | | | 1 | |
| | | | Газар эзэмших эрхийн үнэлгээг нормативын аргыг ашиглан үнэлж бүртгээгүй байна. | Газар эзэмших эрхийн үнэлгээг хийлгэж Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах. | | | | | | | | | | | 1 | |
| | | | Нийт авлагаас 184.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр | 1 | 184.1 | | | | | 1 | 184.1 | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үүсгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах. | | | | | | | | | | | | |
| | | | Тэтгэмж, урамшууллын зардлаас: Аймаг, сум, орон нутгийн нэрийг алдаршуулж буй спортын тамирчинд 10.0 сая төгрөг, байгууллагуудын түүхт 100 жилийн ойн зориулан 11.5 сая төгрөг, Бөхийн холбоонд 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. | Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" | 1 | 24.7 | | | | | 1 | 24.7 | | | | |
| | | | Компани нь нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд нийт цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын ажил хийх эрхтэй боловч 10.0 хувиас хэтрүүлэн 2021 онд 1.0 тэрбум төгрөгийг төлөвлөж, зарцуулсан. | Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д "Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 76.1.18-т"энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал", Компанийн | 1 | 1,000.0 | | | | | 1 | 1000.01 | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүрмийн 7.3.131-д "Санхүүгийн жил дууссаны дараа, тухайн жилийн ашигт ажиллагааны түвшинг харгалзан компанийн цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр орон нутаг (аймаг, сум)-т нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, уг хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ, зарцуулалтад нь нийт энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн саналыг тэдгээрийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тусгаж хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргах" | | | | | | | | | | | | |
| | | | Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны | Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийж | 1 | 2,376.9 | | | | | 1 | 2,376.9 | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 207 тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал" | Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал" -ыг мөрдөж ажиллах. | | | | | | | | | | | | |
| ДҮН | | | | | 6 | 3,585,6 | | | | 4 | 3,585,6 | | | | 2 | |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | | |
| ДҮН | | | | | | | | | | | | | | | | |
| НИЙТ ДҮН | | | | | 6 | 3,585.6 | | | | 4 | 3,585.6 | | | | 2 | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР С.ШИЙЛЭГМАА

**Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт**

**Аудитын нэр:** Санхүүгийн тайлангийн аудит **Аудитын код:** ӨВА-2022/1/НА-СТА-ОНА

**Байгууллагын нэр:** Баянтээг ХК

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянган төгрөг/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын холбогдох хүний | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | НББ-н хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байх | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй байна. | | Зөвлөмж өгөх | | НББ-ийн тухай хуулийн 18.2.Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавархт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана | Зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Н.Данзан, Ю.Ариунтунгалаг |
| 2 | Биет бус хөрөнгө | Газар эзэмших эрхийн үнэлгээг нормативын аргыг ашиглан үнэлж бүртгээгүй байна. | | Зөвлөмж өгөх | | Газар эзэмших эрхийн үнэлгээг хийлгэж Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах. | Зөвлөмж өгөх | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Н.Данзан, Ю.Ариунтунгалаг |
| 3 | Авлага | Нийт авлагаас 184.1 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | 184127.9 | Албан шаардлага | | Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах. | Албан шаардлага | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Н.Данзан, Ю.Ариунтунгалаг |
| 4 | Мөнгөн хөрөнгө | Тэтгэмж, урамшууллын зардлаас: Аймаг, сум, орон нутгийн нэрийг алдаршуулж буй спортын тамирчинд 10.0 сая төгрөг, байгууллагуудын түүхт 100 жилийн ойн зориулан 11.5 сая төгрөг, Бөхийн холбоонд 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. | 24700.0 | Албан шаардлага | | Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 25.10-т "Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно" | Албан шаардлага | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Н.Данзан, Ю.Ариунтунгалаг |
| 5 | Мөнгөн хөрөнгө | Компани нь нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд нийт цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын ажил хийх эрхтэй боловч 10.0 хувиас хэтрүүлэн 2021 онд 1.0 тэрбум төгрөгийг төлөвлөж, зарцуулсан. | 1000000.0 | Албан шаардлага | | Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д "Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ хууль болон компанийн дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 76.1.18-т"энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бусад асуудал", Компанийн дүрмийн 7.3.131-д "Санхүүгийн жил дууссаны дараа, тухайн жилийн ашигт ажиллагааны түвшинг харгалзан компанийн цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр орон нутаг (аймаг, сум)-т нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, уг хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ, зарцуулалтад нь нийт энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн саналыг тэдгээрийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тусгаж хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргах" | Албан шаардлага | Баянтээг ХК-ийн ТУЗ-ийн дарга | Ч.Гүнсэнхорол |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Үндсэн хөрөнгө | Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 207 тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал" | 2376827.2 | Албан шаардлага | | Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийж Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал" -ыг мөрдөж ажиллах. | Албан шаардлага | Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч | Н.Данзан, Ю.Ариунтунгалаг |
| | | **Зөрчлийн дүн** | **3585655.1** | | | | | | |

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 25-ний дотор ирүүлнэ үү.

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР С.ШИЙЛЭГМАА

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

БАЯНТЭЭГ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ДАНЗАН

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ Ю.АРИУНТУНГАЛАГ